

**МОНГОЛЫН ТҮҮХЭНД НЭР ХОЛБОГДСОН ЯПОН
ХҮМҮҮСИЙН ТАЛААР НЭХЭН ӨГҮҮЛЭХ НЬ**

Д.Дашдулам

МУИС, НШУС, Түүхийн тэнхимийн багш (Ph.D)

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэгтээ XX зууны Монголын түүхийн баримтуудад нэр гардаг Япон хүмүүсийн талаар өгүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Японы тагнуул, Коминтерн, хэлмэгдүүлэлт, Баруунтан, зүүнтэн, Танака, Комацубара, А.Амар

1920-30 аад оны үеийн Монголын түүхийн баримтуудад нилээд их гардаг гадаад хүний нэрсийн дотор “Танака” хэмээх Япон хүний нэр ихээхэн анхаарал татдаг билээ. Учир нь Ц.Дамбадорж тэргүүтэй баруунтныг буруушаасан болон “Лхүмбийн хэрэг”, хожмын 1937 оны хэлмэгдүүлэлтийн жилүүдэд баривчлагдан Японы тагнуулын бүлгэмд элсэн, эх орноосоо урвасан хэмээн яллагдан цаазлагсдын дийлэнх нь дээрх нэртэй шууд болон дам холбогдсон байдаг.

Монголчууд энэхүү Япон хүний нэрийг анх хэрхэн хаанаас мэддэг болов? Үнэхээр ийм хүн байсан уу? эсвэл зохиомол хүн байв уу? Хэрэв байсан бол, манай улсын нөлөө бүхий хүмүүс болон энгийн ард иргэдийг тагнуулын ажиллагаандаа татан оруулж, Монгол даяар сүлжээ үүсгэн монголчуудыг тагнуул хийлгэн, улмаар олон мянган хүмүүсийн амь насыг бүрэлгүүлсэн “гайтай” хүн байж гээд олон олон асуултууд ар араасаа ундран гарах нь бизээ.

Миний үзэж байгаагаар, Монголчуудын дунд тархсан Танака гэх нэр бол бодит хүний нэрнээс улбаатай бөгөөд хэрхэн монголчуудын дунд танил болж, “Лхүмбийн хэрэг” болон “Хэлмэгдүүлэлт”-ийн жилүүдэд бүгдээр шахуу яагаад Танакагийн тагнуул болов гэдэг нь ихээхэн сонирхол татсан юм.

Судалгааны явцад Монголчууд түгээмэлээр мэдэх болж, анхлан нэр холбогдон Танака бол Японы Манжуурт сууж байсан консул Танака Буничиро юм. Түүний нэрийг монголчууд хэрхэн хаанаас мэддэг болов гэхээр Танака нараас Монголын удирдлагад хандан, Монголд орох зөвшөөрөл хүссэн үеэс “Танака” гэх нэрийг мэддэг болж хожмын цуутай тагнуулчийн нэр болтлоо мөнхлөгдсөн болов уу. Мөн тухайн үеийн Коминтерны баримтуудад зөвшөөрөл өгсөн Монголын удирдагчдыг ихэд буруушаасан байдаг нь энэхүү Танака хэмээх нэр нь эгнэгт “өөдгүй” хүний нэр болон цээжлэгджээ.

Тиймээс ч Зөвлөлтийн тал Монгол эх орончидтой тооцоо хийж хэлмэгдүүлэхдээ Японтой холбож үнэмшилтэй болгохын тулд монголчуудын нэгэнт өмнө нь мэддэг болсон

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

танил нэрийг ичгүүргүйгээр ашигласан гэж үзэх үндэстэй юм. Гэхдээ Японоос Манжуурт сууж байсан консул Танака нь Монголд тагнуул хийх нь байтугай Монголд огт ирж байгаагүйг хэлэх хэрэгтэй.

Магадгүй Танака бус өөр нэгэн Такахаши ч юмуу Танабэ гэх нэрийг ашиглалаа гэхэд монголчуудад танил бус, чихэнд дасал болоогүй нэр үнэмшил муутай сонсогдох тул 1920-оод оны дунд үеэс мэдэх болсон Танака хэмээх нэрийг ашигласан нь хэлмэгдүүлэлтийг өргөжүүлэн явуулахдаа олон түмний сэтгэл зүйд нөлөөлөх нөлөөг давхар тооцоолсон бизээ.

Японы талын хувьд Монголын үндэсний хувьсгалаас хойш Монголын талаарх ойлголт төдийлэн сайн бус бүрхэг мэдээдэл төдийгээр хязгаарлаж байсан тул эхний удаа Манжуурт суугаа консул Танака дараагийн удаа Москва дахь элчин сайдын яамны цэргийн атташе Комацубара нарыг тус бүр хоёр хүний хамт Монголд илгээн мэдээлэлийнхээ үнэн, худалыг мухарлан газар дээр нь очиж үзүүлэх нь юу юунаас ч илүү гэж үзсэн бололтой.

Бүрэлдхүүнийг ч сонгохдоо ихээхэн анхаарсан нь харагддаг бөгөөд Танакагийн хувьд мэргэжлийн дипломатч, харьцангуй Монголын талаар мэдлэгтэй, Өвөр монголчуудтай харьцаж сурсан хүн гэж хэлж болно. Комацубарагийн хувьд бага наснаасаа цэргийн сургуулиар дамжсан ясны цэргийн хүн бөгөөд Оросын талаар цэргийнхэн дундаа мэргэжсэн цөөхөн хүмүүсийн нэг юм.

Нэгэнт бүрэлдхүүн болон зорилго тодорхой болсон тул Монголын талд хандан нэр бүхий хүмүүст орох виз хүссэний дагуу Монголын тал ч элдэв чирэгдэл хүндрэлгүйгээр тэдэнд виз олгон хил нэвтрэх зөвшөөрөл өгчээ. Яагаад элдэв чирэгдэлгүйгээр гэхээр Монголын тал нэгэнт тусгаар тогтносон улсын хувьд энэ нь хэнээс ч хамааралгүйгээр асуудлыг шийдэх нь зүй ёсны хэрэг хэмээн үзжээ.

Гэвч энэ нь Зөвлөлтийн талаас хатуухан сануулга, зэм хүртэж, тэднийг оруулахыг зөвшөөрсөн визийг хүчингүйд тооцож, Монголын тал гадаад улсын өмнө тун ч “эвгүй” байдалд орсон юм.

Монголын удирдлагад хандан Манжуурт суугаа Японы консул Танака нь ойр дөтийг бодоод Монголын зүүн хязгаараар нэвтрэх хүсэлтэйгээ илэрхийлжээ. Тэрбээр хоёр хүний хамт Санбээсийн хүрээгээр дамжин Улаанбаатарт очих бодолтой байсан боловч Монголын талыг учир үл мэдэгдэх шалтгаанаар түтгэлзэх болсон тул Алтанбулагаар нэвтрүүлж¹ өгөхийг хэдэн удаа хүссэн байх ба нэг жил орчим тэвчээртэй хүлээгээд ч нааштай хариу авч чадаагүй байдаг.

¹ Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүдтэй тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага, УБ,

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Танакагийн аялалын зорилгыг “Манжуур дахь консул Танака нь 1927 онд Монголд очихыг хүссэн нь тэнд Зөвлөлтийн нөлөө оролцоо хир их байгааг олж мэдэхийг хүссэн байж болох талтай”² хэмээн үзсэнтэй санал нэг байгаа бөгөөд үнэндээ Японы тал Монголын талаарх мэдээлэлийг шалган цэгцэлж, ойлголтоо нэг мөр тодорхой болгон дараагийн зүйлээ төлөвлөхөд дөхөмтэй байсных бизээ.

Нэгэнт Манжуурт суугаа консул Танакад олгогдсон виз учир битүүлэг байдлаар хүчингүй болж дахин, дахин хандсан хэдий ч Монголын удирдлага нааштай хариу өгөхгүй байсан тул Японы тал бүрэлдхүүнийг өөрчилж, Москвад суух элчин сайдын яамны цэргийн атташег өөр хоёр хүний хамт илгээх хүсэлтэйгээ 1927 оны хавраас мэдүүлэн очих хугацааг товлон Алтанбулагаар хил нэвтрүүлж Улаанбаатарт очуулан долоо хонуулах л төлөвлөгөөтэйг уламжлан виз хүсчээ.³

Монголын засгийн газар энэ удаа Японы цэргийн атташед мон л зөвшөөрөл олгосон байдаг. Үүний дагуу Москвад суугаа Японы элчин сайдын яамны цэргийн атташе Комацубара долдугаар 23-нд Москвагаас гарч 29-ны өдөр Учинск-г хүрээд 31-нд Алтанбулагт ирж наймдугаар сарын 1-нд Улаанбаатарт хүрээд долоо хонох төлөвлөгөөтэй байжээ. Комацубараг Алтанбулагт тусгай хүн угтахаар тохиролцсон бололтой. Яагаад тохиролцсон бололтой гэхээр харилцсан бичгийн дотор Алтанбулагаас хүн тосох тухай дурьдсан байдгаас харахад хоёр тал энэ талаар ярьж тохиролцсон нь харагдаж байна.

Гэтэл дараахан Зөвлөлтийн талаас ирсэн мэдээнд “цэргийн атташег ирүүлэх аваас их л тусгүйгээр үл барам наанадаж СССР-тэй найрамдал алдагдах цаанадаж Дундад улстай найрамдахад харшлалтай болох учир бид нар зөвлөлдөн мөнхүү цэргийн атташегийн биеийг Дээд-Үд хотоос хойш буцаахаар тусгай хүнд бичиг авахуулан нисэх онгоцоор мордуулсан”⁴ хэмээн Монголын талд урьдчилан мэдэгдэлгүйгээр зохицуулалт хийчихээд мэдэгджээ.

Энэ мэдээг аваад Ц.Дамбадорж нараас хариуг өгөхдөө: “Нэгэнт зөвшөөрөл олгоод хязгаар дээрээс буцаах нь үнэхээр элчин сайд, нийтийн харилцааны явдалд үзэмжгүй тэрхүү атташег Монголд очиж буцаасан төдийгөөр СССР улстай найрамдал алдагдахад хүрэхгүй буй за гэж санагдмой. Харин энэ хэргээс наанадаж тус улсын элчин сайдын яам, олон улсын элчин сайдын дотор нэр хүндгүй, итгэмжгүй гэгдэн хэдий нь манай улсын сүрд харшлалтай болох

1932, II дэвтэр., 11 дэх тал

² Ц.Батбаяр., Монгол ба Япон XX зууны эхэн хагаст., УБ., 1998., 59 дэх тал

³ Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүдтэй тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага, УБ.

1932, II дэвтэр., 18 дах тал

⁴ Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүдтэй тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага, УБ.

1932, II дэвтэр., 20 дахь тал

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

болов уу. Тиймийн тул энэ удаа тэр атташег очуулваас зүйтэй болов уу гэж учирлан Дамбадорж, Дорлигжав нар ёслол”⁵ гэсэн хариуг илгээжээ.

Гэсэн хэдий ч Зөвлөлтийн тал Монголын удирдлагын саналыг үл хэрэгсэн Японы атташег Дээд -Үдээс гэдрэг буцаасан байдаг. Японы төлөөлөгчдийг Монголд оруулах эсэхийг КИГХ-ны Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар хэлэлцээд оруулахгүй байх шийдвэрийг тус газрын 1927 оны нэгдүгээр сарын 17-ний өдөр гаргасан тогтоолын 6 дугаарт⁶ гаргасан байдаг.

Мөн 1927 оны зургадугаар сарын 1-нд гаргасан тогтоолд “Японы албан ёсны төлөөлөгчийг Монголд үл оруулах тухай асуудал нэгэнт шийдвэрлэгдсэн тул дахин хянаж үзэх хэрэггүй гэж үзнэ”⁷ хэмээн дахиж энэ асуудлыг сөхөж гаргахгүй байхыг хатуу анхааруулжээ. Үүнээс харахад цаг хугацааны хувьд бараг хагас жилийн дараа дахин тогтоол гаргасан нь Япон тал дахин, дахин хүсэлт гаргаж байсныг Монголын тал өгөх хүсэлтэй байсныг батлахын хамт цаашилбал үүнээс хойш Япон төдийгүй гадныханд виз олгож болохгүй гэдгийг Монголын талд хатуу анхааруулсан хэрэг байлаа.

Монгол улс нь бие даасан тусгаар улс хэдий ч гадаад улсуудтай харилцах эрх мэдэлгүй, дан ганцхан Зөвлөлттэй харилцдаг хэдий ч эрх тэгш, хамтын ажиллагаан дээр бус өөрийн хяналтанд бүрэн оруулах ажиллагаагаа аль хэдий нь гүйцэлдүүлээд эхэлсэнийг харуулж байна.

Тухайн үеийн гадаадын сэтгүүлүүдэд “Гадаад Монгол улаан Оросын колони боллоо”, “Оросын дарангуйлалд” гэх зэргээр бичиж байсан нь зүгээр ч нэг бичсэн хэрэг бус бодит байдлаас гарсан дүгнэлт байжээ.

Түүхч, доктор Ц. Батбаяр “1927 оны эцэс, 1928 оны эхээр Японы цэргийнхэн, мөн ГЯЯ-ны хүрээнд Гадаад Монгол дахь Зөвлөлтийн оролцоо асар их болж, Гадаад Монгол нь үндсэндээ Зөвлөлтийн нэг хэсэг болж хувирч байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Манжуур дахь консул Танака 1927 онд Монголд очихыг хүссэн нь тэнд Зөвлөлтийн нөлөө оролцоо хэр их байгааг олж мэдэхийг хүссэн байж болох талтай”⁸ гэж үзсэнтэй санал нэг байна.

Ийнхүү Японы талаас 1926, 1928 онд хоёр удаа Монголд төлөөлөгчөө илгээх гэж идэвхтэй оролдсон нь талаар болсон юм. Магадгүй энэ нь Монголын талын байр суурь биш гэдгийг ч тэд сайн мэдэж байсан бизээ.

⁵ Мөн тэнд., 21-22 дах тал

⁶ Коминтерн ба Монгол, УБ, 1996, 135-136 дах тал

⁷ Мөн тэнд., 141 дэх тал

⁸ Ц.Батбаяр., Монгол ба их гүрнүүд XX зууны эхний хагаст., УБ.,2006., 131 дах тал

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Японы төлөөлөгчдөд виз зөвшөөрөл олгохыг дэмжсэн Дамбадорж нарыг хожим баруунтан, зүүнтэний зөрчилт тэмцэлийн үед “ЗХУ-аас салж холдон Японтой ойртох хэмээсэн” гэж буруушаах бас нэгэн үндэслэл нь дээрх явдал болсон билээ.

Нэгэнт Хятдад суугаа Японы консул Танакад виз олгогдоогүй тул Японоос Зөвлөлтөд суугаа элчин сайдын яамны цэргийн атташе Комацубараг очуулах хүсэлтээ гаргажээ. Энэ нь нэгэнт консул Танакаг хэд хэдэн удаа очуулах хүсэлт гаргаад виз авч чадаагүй тул Зөвлөлтөд ажиллаж буй ажилтанаа илгээх хүсэлт гаргажээ. Үүнийг нэг талаас хүнээ сольж арга барсан гэмээр боловч нөгөө талаар Зөвлөлтийн тал болгоомжлоод буй аваас Зөвлөлтөд ажиллаж буй Япон ажилтанд эрх биш виз өгнө гэж найдсаных бизээ.

Тухайн үед Москва дахь Монголын элчингийн ажилтануудтай Японы элчин сайдын яамны ажилтанууд уулзаж, ярилцаж байсан баримт байдаг ба Комацубарагаас “... Азийн улсууд хоорондоо зузаан хэлхээ байгуулж элдэв янзын сэжиг тааваргүйгээр бие биеэ итгэлцэн хүчнийг зузаатгаж элдэв зүйлийг сайжруулж элдэв хэрэг бэлэн болсны эцэс дор улс төрийг хүлээлгэвээс ашигтай болохоос бус эл зүйлийг явуулсангүйгээр улсыг хүлээлгэхэд танай улсад ашиг тус үгүй буй заа”⁹ хэмээн хэлсэн нь тэмдэглэгдэн үлджээ.

Түүний дээрх үгээр шалтаглан 1928 оны 8 дугаар сарын 2-нд Монголын ГЯЯ-наас Тройцкосавскад ирээд байсан Комацубарад мөн л татгалзсан бичиг хүргүүлсэн байдаг. Уг бичигт, “Таны бие Москвад Гомбо нар лугаа хэлэлцсэн дор сэжиг учир бүхийн дээр энэ хир Дундад иргэн улсын үндэсний засгийн газар эрхэм улсын засгийн газар лугаа харилцан үл зохилдох явдал гарч Манжийн мужуудад будлиан хэрэг үүссэн бүхий энэ үест эрхэм таныг манай улсад ирүүлж харилцваас үл зохилдох тул урьд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгон түр түтгэлзвээс зохихыг мэдэгдмүй”¹⁰ гэжээ.

Үүнээс харахад мөн л урьд өмнө өгсөн зөвшөөрөлөөсөө татгалзсан нь харагдаж байгаа бөгөөд нөгөө талаар Коминтерны их хурлуудын илтгэл болон түүнээс гарсан тогтоолууд дахь Японы талаарх болгоомжлолтой ерөнхийдөө адилхан үг хэллэг хэрэглэснээс харахад аанай л Зөвлөлтийн шийдвэр байсан нь тодорхой юм.

Энд сонирхуулан хэлэхэд цэргийн атташе Мичитаро Комацубара нь үе дамжсан цэргийн албан тушаалтаны гэр бүлд төржээ. Бүр бага наснаасаа эхлэн цэргийн сургуулиар дамжин шалгарч өндөрлөгт хүрсэн “ясны” гэмээр цэргийн хүн болсон ба Японы Цэргийн Төв штабын Европ, Оросын тагнуулын хэлтэст ажиллаж болжээ. Оросын талаар бэлтгэгдэн мэргэжсэн

⁹ Мөн тэнд

¹⁰ МАХН-ын Төв Архив., Ф.1.Д.3.ХН.143

чадварлаг нэгэн байсан төдийгүй хоёр ч удаа Москва дахь Японы элчин сайдын яаманд томилогдон цэргийн атташегийн туслах, атташегаар нийтдээ таван жил гаран ажилласан байдаг.

Түүний намтараас харахад цэргийн хүний энгийн намтар мэт хэдий ч хамгийн сонирхол татсан нь дэслэгч генерал Комацубара 1938 оны долдугаар сараас 23-р дивизийн захирагч болсон ба Халхын голын дайнд Японы цэргийн тулалдааны хүндийг үүрч тулалдсан Квантуны армийн гол найдвараа тавьж байсан дивизийн захирагч байсан юм.¹¹

Хүмүүний тавилан төөрөг, хувь заяа ихээхэн сонирхолтой бөгөөд тэртээ 1928 онд Монголд нэвтрэх визийг албан ёсоор хүсэж байсан Комацубара арав гаран жилийн дараа Монголын хилийг цэргийн хүчээр зөрчөөд орох гэж оролдсон нь цэргийн хүний тушаал ыг дагсан хэрэг бизээ.

Япон хүний мөн нэр холбогддог бас нэгэн зүйл бол “Лхүмбийн хэрэг” түүний дараагаар гарсан улс төрийн хилс хэргүүд бөгөөд түүнд олон мянган хүн холбогдон амь насаа алдсан билээ. Ингэх тодорхой шалтгаан, нөхцөл байсан ба ялангуяа Манжуур дахь Японы цэргийнхэний ажиллагаа идэвхжиж, Манжго улс байгуулагдан хил залгаа орших болсонд Зөвлөлтийн тал юунаас ч илүү түгшиж байсан юм. Тэд улс төр, эдийн засгийн хувьд нөлөөгөө тогтоож чадсан ч гэлээ олон түмэн, тэр дундаа феодал байгсад, лам нарыг хамгийн түрүүн Япончуудтай холбоо тогтоож сүүжрэх найдваргүй хүмүүс хэмээн хардсаар байлаа.

“Лхүмбийн хэрэг”-ээр халхавчлан Зөвлөлтийн тал олон зорилгоо гүйцэлдүүлснийг энд хэлэх нь илүүц бөгөөд гагцхүү Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ж.Лхүмбэ нь Японы тагнуул Танака болон баргуудтай холбоотой байж ерөнхий удирдлагаар хангагдаж байсан хэмээх ойлголтыг нийгэмд төрүүлэх нь л чухал байсан юм. Үүнийгээ үнэмшилтэй болгохын тулд тухайн үеийн нам, төрийн өндөр алба хашиж байсан хүмүүсийг холбогдуулан гадаадын болон дотоодын эсэргүү хүчний нарийн зохион байгуулалттай ажиллагаа бодитой байсан тул олон мянган хүмүүсийг баривчилж шийтгэж байгаа мэт сэтгэгдэлийг төрүүлсэн ажээ.

Тэднийг Японы цэргийнхэнийг нутагтаа оруулах нууц хуйвалдаан хийж байсан асар том бүтэц бүхий байгууллага хэмээн ойлгуулаад толгой дараалуулан Танакагийн тагнуул байсан гэж шийтгэсэн юм.

¹¹ Alvin D.Coox.Nomonhan. Japan against Russia, 1939., Stanford California, 1985, vol., p.175

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Энд сонирхуулан хэлэхэд 1936 оны 4 дүгээр сарын 3-нд “Хувьсгалын эсэргүү лам нарын хэрэг” -ийг таслан шийтгэсэн байх ба Номонхан Гончигдоо нь Дотоодыг хамгаалахын тусгай даалгавар гүйцэтгэж байсан ажилтан бөгөөд түүнийг Инокучи, Тачибана, Сайто нартай дотно холбоо байгуулан тэдний тагнуулын ажилд идэвхтэй оролцсон хэмээн буруутгажээ.¹²

Дээрх Инокучи, Сайто хэмээх хүмүүс Манжуурын бага хурлын үед Манжгогийн талын бүрэлдхүүнд орж ажилласан хүмүүс бөгөөд Инокучи нь Монголд хэсэг хугацаанд шоронд сууж байхдаа монгол хэлийг шамдан сурсан бөгөөд хурлын үеэр орчуулагч хийж байжээ.¹³

Манжуурын хэлэлцээрт оролцогсод мөн л Япон хүнтэй нүүр тулж уулзсан цөөхөн монголчуудын нэг болсоныхоо хувьд “Гэндэн Дэмидээр удирдуулсан хувьсгалын эсэргүү, Япон тагнуулын хэрэг”- т холбогдон хэлмэгдсэн юм.

Хэлмэгдүүлэлтийн үеийн нэлээд шувтаргаар баривчлагдсан Ерөнхий сайд А.Амарын мэдүүлэгийн талаар энд дурьдахгүй байхын аргагүй юм. Учир нь түүний мэдүүлэгүүд ихээхэн эмх цэгцтэй, үгийн сонголт хоёрдмол утгагүй тодорхой хэлсэн байдаг нь түүний боловсрол, эх бичгийн эрдэмтэн байсныг илэрхийлээд зогсохгүй хүнийхээ хувьд ямар ч үед байгаагаараа байж чадсан ховорхон төрсөн эгэл сайхан хүний төрхийг харуулдаг юм.

Ялангуяа хэрэгт холбогдон баривчлагдсан хүмүүсийн мэдүүлгийг уншиж байхад цагийн аяс, өш хонзон, аргаа барсанаас болсон боловуу гэмээр хүний олон зан чанар холилдон харагддаг бол А.Амарын мэдүүлэгүүд ямар ч үед бусдыгаа барьж өгөөгүй, өөрөөрөө л дуусгаж олон хүнийг холбогдуулахгүй байх гэсэн эх орончын үнэр ханхалдаг бөгөөд мөн энэ бүхний гол буруутныг хэлж үлдээсэн цөөхөн хэдэн хүний нэг болдогоороо онцлогтой юм.

Түүний мэдүүлэгтэй танилцах боломж сүүлийн үед нээлттэй болсон нь Монголын түүхийн олон чухал асуудлыг тодруулах бололцоог судлаачдад олгосон юм. Түүхч, доктор Д.Өлзийбаатар А.Амарын урьд өмнө хэвлэгдэж нийтэд мэдэгдээгүй байсан нэгэн мэдүүлгийг судалгааныхаа бүтээлд хэвлүүлсэн байдаг.¹⁴

А.Амарын мэдүүлэг нь эрхэлж байсан ажил албанаасаа шалтгаалаад агуулгын хувьд өргөн хүрээтэй бөгөөд Монголын түүхийн ээдрээтэй нугачаатай үеийн талаар олон сонин зүйлийг хэлсэн байдаг ба энд зөвхөн Японтой холбоо бүхий хэсгийг түүвэрлэн авч үзье.

¹² Д.Дашдулам., “Манжуурын хэлэлцээр ба хэлмэгдүүлэлт”, “Цэргийнхэн ба хэлмэгдүүлэлт” эрлэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл., УБ., 2007

¹³ 北川四郎., ノモンハン: 元満州外交官の証言., 東京現代史出版社., 1979. p., 108

¹⁴ Д.Өлзийбаатар., Яагаад 1937 он., УБ., 247-253 дахь тал

* Манжуур дахь консул Танакаг Москвад байсан гэж ташаарчээ. (Д.Д)

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

А.Амарыг 1939 оны 3 дугаар сарын 30-31-нд байцаасан мэдүүлэгт, Японтой холбоотой зүйлийн талаар дэлгэрэнгүй хэлж өгүүлсэн байдаг.

Түүний мэдүүлэгт, “Японы өдөөн хатгасанаар би Монголын овог аймгуудыг нэгтгэж, аугаа их улс байгуулах хүсэлтэй байлаа. Хэрэв сайн ажиглавал манай олон хүн ийм бодолтой бөгөөд Японы тусламж авч, хэрэгжүүлэх хүсэлтэй байдгийг мэднэ. Гэвч тэр үед бие биенээ их харддаг, бусдынхаа хүсэж явдаг юмыг нууцхан мэддэг боловч ил хэлдэггүй байлаа.

1928-1929 онд Москвад байсан Японы атташе Танака* Монголд ирэх тухай асуудал тавьж, би түүнийг ирүүлэхээр хичээсэн боловч бүтээгүй” гээд Дамбадорж, Жадамба, Жамсранов нарыг болон мөн өөрийг нь үүгээр дөрөөлөн баруунтан хэмээн шүүмжилсэн талаар өгүүлжээ.

Мөн цааш нь тэрбээр, “Япон-Монголын хэлэлцээрт Самбууг хоёр дахь удаагаа явахад нь хэлэлцээрт оролцох Инокучи урьд нь Монголд амьдарч байсан, Монголын нөхцөлийг мэддэг гэсэн сургаар өөрөө танил биш ч гэсэн, Самбууг таньдаг гэдгийг мэдээд түүнд миний гарын үсэг бүхий захиаг дамжуулахыг Самбуугаас хүссэн. Би захидалдаа Монгол улс аугаа их Япон улстай найрамдалт харилцаа тогтоохыг хүсч буй учир энэ асуудлыг хэлэлцээртээ оруулахыг хүсч бид ч гэсэн үүний тулд эндээс хүчин чармайлт гаргана гэдгээ мэдэгдсэн. Самбуугаар ирүүлсэн хариундаа, хэзээ нэгэн цагт Япон, Монгол хоёр улс найрамдалын холбоо тогтооно, тэд- Япончууд үүнд байнга санаа тавьдаг, монголчууд ч бодитой арга хэмжээ авах хэрэгтэй” гэжээ.

Үүгээрээ Зөвлөлтийнхэний хэлэхийг хүссэн зүйлийг хэлээд зогсохгүй нэр дурьдагдсан Самбуу нь Ерөнхий сайдын II орлогч байсан Г.Самбуу бөгөөд 1937 онд анхлан баривчлагдан “Анхны 14-ийн хэрэг”-т цаазлагдсан нэгэн тул түүний нэрийг хэдэнтээ дурьдсан байдаг.

А.Амар мэдүүлэгийнхээ төгсгөлд, “Японы империалистууд манай улсад хорлон сүйтгэх ажиллагаа, өдөөн хатгалаг явуулж, хилийн маргаан гарган улсын гүнд тагнуул туршуулаа оруулж мөн дотоодын феодал, лам нар, эх орноосоо урвасан эсэргүү нарыг ашиглан янз бүрийн аргаар улс орны соёл боловсрол, аж ахуйн хөгжлийг ч саатуулж, улс орны амьдралын бүх салбарт байнга хорлон сүйтгэх ажиллагаа явуулж, эгнээндээ олон хүмүүсийг татан оролцуулж байсан нь байнга баривчилгаа явуулж цус урсгахад хүргэн ард түмний тайван амьдралыг бусниулсан. Үүнээс гадна Японы империалистуудын өдөөн хатгалагыг няцаах, газар сайгүй байгаа тагнуул туршуулыг мөрдөж илрүүлэн баривчлахад маш их хөрөнгө зарсан ба явуулсан хорлон сүйтгэх ажлаас маш их хохирол амссан. Хэрвээ Монгол ийм заваан ажил хийж байхын

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

оронд улс орондоо улс орноо хөгжүүлэх ажил явуулж байсан бол хэд дахин илүү хөгжиж, бэхжих байв.

Иймээс Монгол эх орноо хайрлаж хамгаалдаг, үй олноор баривчилж цус урсгах явдлыг зогсоож тайван амьдрахыг хүсдэг хүн бүр гэмийн ажиллагаагаа хүлээн зогсоож, орчин үедээ зохицоогүй ялзарсан үндсэрхэг үзлээсээ салж, мөхөж буй Японд итгэж түшиглэнэ гэсэн тэнэг бодлоо орхих, эх орон, үндэсний хувьсгалын төлөө үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй. Иймээс Монголд ямар нэгэн баривчилгаа явуулж цус урсгах явдлыг зогсоон ард олонд тайван амьдрах боломж олгох явдал зайлшгүй хэрэгтэй гэж үзэн өөрийн гэмээ бүрэн хүлээхээр шийдсэн. “Монголын бүх овог аймгийг нэгтгэнэ” гэсэн хуурамч лоозунгаар халхавчлан, Японы империалистууд Монголыг эзлэхийг зорин, Монголын засгийг унагах гэж туршуулын ажил явуулж байсныг илэн далангүй ярьсан...” гээд гээд гарын үсгээ зуржээ.

Үүнээс харахад А.Амар нь Ерөнхий сайд байсны хувиар Монгол- Зөвлөлтийн болон Коминтерны харилцааны олон сэжүүрийг мэдэж байсныгаа гэрчийн хувьд гүн агуулгаар гаргахын хамт Зөвлөлт- Японы ашиг сонирхолын мөргөлдөөнд монголчууд, Монгол үндэстэн хэрхэн хохирсон болохыг зоригтойгоор хэлсэн байдаг.

Монголын түүхэнд нэр холбогдсон Япон эдгээр хүмүүсийг таньдаг, танихгүй нь хамаагүй ажил төрлийн шугамаар нэр холбогдсон л бол эх орноосоо урваж, Японы тагнуулын бүлэгт элсэн орсон хэмээн цаазалдаг байсан бол хэлмэгдүүлэлт гүнзгийрэн өргөжихийн хирээр хэн дуртай хүнээ дээрх хэдхэн нэртэй холбоод Японы тагнуул болгон цаазалдаг хатуу хууль үйлчлэн олон мянган жирийн иргэд цаазлагдсан билээ.

Abstract

This scientific article is about Tanaka and Komatsubara - people who are related to the history of the 1920-1930s of the XX century. In particular, name Tanaka was very popular in Mongolia during the years of the “Lhumbe case” and the “Great repression” when almost every person involved in the political repression was considered to be a member of Tanaka’s spy group. In that particular time, as I believe, there was no such Japanese spy as Tanaka and it is likely that the soviets have made this up on purpose. This is the main idea I tried to present in my article.

In the mid 20-ies, there was an actual person, Tanaka Bunichiro, who served as the Japanese Consul in Manchuria and was first issued a Mongolian visa, but then was refused by the Mongolian side under the pressure of the soviets. Party leaders who issued him a visa were later blamed for attempting to breaking away from Comintern and the Soviet Russia. The conclusion I made is that the name Tanaka became popular among Mongolians since this event.

As for Komatsubara, Mongolians know about him from the history of the Halha river war. However, I have found facts that Komatsubara contacted Mongolian before the war, about which I wrote my article.